



**МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР**



СПОРТЫН АРБИТРЫН ЗАРДЛЫН ЖУРАМ

2024 оны 08 дугаар сарын 12-ны
өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлнэ.

Удирдах зөвлөлийн
2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 24/12 тоот
тогтоолын хавсралтаар батлав

**МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТРЫН ЗАРДЛЫН ЖУРАМ**

Нэг. Олон улсын маргааны арбитрын ажиллагаанд

1.1 Зардлын хэмжээг нэхэмжлэлийн үнийн дүнгээс доорх хувь хэмжээгээр тогтооно.

Үүнд:

№	Нэхэмжлэлийн үнийн дүн	Арбитрын зардал /ам.доллар/
1	-10,000	1,000
2	10,001-50,000	1,000 дээр 10,000-аас дээш үнийн дүнгийн 3.0 хувиар
3	50,001-100,000	1,770 дээр 50,000-аас дээш үнийн дүнгийн 3.0 хувиар
4	100,001-200,000	3,270 дээр 100,000-аас дээш үнийн дүнгийн 3.0 хувиар
5	200,001-500,000	6,270 дээр 200,000-аас дээш үнийн дүнгийн 2.5 хувиар
6	500,001-1,000,000	13,770 дээр 500,000-аас дээш үнийн дүнгийн 2.0 хувиар
7	1,000,001-аас дээш	23,770 дээр 1,000,000-аас дээш үнийн дүнгийн 1.5 хувиар

1.2 Нэхэмжлэлийн шаардлагыг мөнгөн дүнгээр илэрхийлэх боломжгүй тохиолдолд үндсэн зардлын хураамжийг доорх хэмжээгээр тогтооно. Үүнд:

№	Нэхэмжлэлийн үнийн дүн	Арбитрын үндсэн зардал /ам.доллар/
1	Арбитрын зардал	5,000

Хоёр. Дотоодын маргааны арбитрын ажиллагаанд

2.1 Зардлын хэмжээг нэхэмжлэлийн үнийн дүнгээс доорх хувь хэмжээгээр тогтооно.

Үүнд:

(Төгрөг)

№	Нэхэмжлэлийн үнийн дүн	Арбитрын зардал
1	10,000,000 хүртэлх	1,000,000 төгрөг
2	10,000,001-50,000,000	1,000,000 дээр 10,000,000-аас дээш үнийн дүнгийн 8.5 хувиар
3	50,000,001-100,000,000	1,500,000 дээр 50,000,000-аас дээш үнийн дүнгийн 7.5 хувиар
4	100,000,001-200,000,000	2,000,000 дээр 100,000,000-аас дээш үнийн дүнгийн 4.5 хувиар
5	200,000,001-500,000,000	2,500,000 дээр 200,000,000-аас дээш үнийн дүнгийн 2.5 хувиар

6	500,000,001- 1,000,000,000	7,425,000 дээр 500,000,000-аас дээш үнийн дүнгийн 2.0 хувиар
7	1,000,000,001-аас дээш	12,425,000 дээр 1,000,000,000-аас дээш үнийн дүнгийн 1.0 хувиар

2.2 Нэхэмжлэлийн шаардлагыг мөнгөн дүнгээр илэрхийлэх боломжгүй тохиолдолд зардлын хураамжийг доорх хэмжээгээр тогтооно. Үүнд:

№	Нэхэмжлэлийн үнийн дүн	Арбитрын зардал
1	Арбитрын зардал	10,000,000 төгрөг

2.3 Архивын болон нотлох баримтын хуулбар, лавлагаа гаргуулах тохиолдолд доорх хураамжийн хэмжээгээр тогтооно.

№	Утга	Төлбөр
1	Архивын хуулбар	Хуудас тутамд 5,000 төгтөг
2	Лавлагаа	50,000 төгтөг
3	Арбитраар дамжуулан авах лавлагаа, тодорхойлолт	200,000-5,000,000 төгрөг

Гурав. Арбитрын ажиллагааны зардал

- 3.1 Арбитрын зардалд Монголын Олон улсын ба Үндэсний Спортын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдон гарах дараах санхүүжилт хамаарна. Үүнд:
 - 3.1.1. Арбитрын үйлчилгээний
 - 3.1.2. Арбитрын захиргааны үйл ажиллагааны
 - 3.1.3. Арбитрч болон нарийн бичгийн даргын ажлын цалин хөлс
- 3.2 Нэхэмжлэл гаргасан тал эхний ээлжинд арбитрын зардлыг дээрх хувь хэмжээгээр төлнө.
- 3.3 Сөрөг нэхэмжлэл гаргасан тал нэхэмжлэгчийн нэгэн адил арбитрын зардал төлнө.
- 3.4 Нэхэмжлэгч арбитрын зардлыг хэсэгчлэн төлөх талаар арбитрт хүсэлт гаргаж болно. Хэсэгчлэн төлөх эхний зардлын доод хэмжээ арбитрын нийт зардлын 50 хувиас доошгүй байна. Үлдэх хэсгийг арбитрын хуралдаанаас өмнө бүрэн төлсөн байна.
- 3.5 Монголын Олон улсын ба Үндэсний Спортын арбитрын холбооны дансанд арбитрын зардлын төлбөр орсноор уг зардлыг төлсөнд тооцно. Уг зардлыг дансанд оруулах үүргийг нэхэмжлэгч, түүний гүйцэтгэлийг шалгаж хэрэгжүүлэх үүргийг Монголын Олон улсын ба Үндэсний Спортын арбитрын Ажлын алба хариуцна.
- 3.6 Олон улсын маргааны арбитрын зардлын төлбөрийг АНУ-ын доллараар тооцож, ‘Төв банкны тухай’ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу нэхэмжлэл гаргах өдрийн Монголбанкнаас зарласан албан ёсны ханшаар тооцож Монгол төгрөгөөр төлнө.
- 3.7 Олон улсын маргааны арбитрын зардал нь АНУ-аас өөр улсын валютаар үнэлэгдсэн тохиолдолд арбитрын зардлыг арбитрт нэхэмжлэл гаргах үеийн Монголбанкнаас зарласан албан ёсны ханшаар тооцно.

- 3.8 Дотоодын маргааны нэхэмжлэлийн үнийн дүн АНУ-ын доллараар эсвэл өөр улсын валютаар үнэлэгдсэн тохиолдолд арбитраж нэхэмжлэл гаргах өдрийн Монголбанкнаас зарласан албан ёсны ханшаар тооцож арбитраж зардлыг төлнө.
- 3.9 Нэхэмжлэл, сөрөг нэхэмжлэлийн талаар арбитраж ажиллагаа хийх явцад болон шийдвэр гаргах үедээ зарцуулсан бодит зардлыг тооцож тухайн арбитраж бүрэлдэхүүн нэхэмжлэлийн үнийн дүнг тодорхойлож, зардлын хэмжээг тогтооно.
- 3.10 Энэ журмын 1.2 болон 2.2 дахь хэсэгт заасан зардлыг арбитражаас буцаан олгохгүй.

Дөрөв. Арбитраж ажиллагааны нэмэлт зардал

- 4.1. Нэмэлт зардалд тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд холбогдох бусад зардал багтана. Үүнд: шинжээчтэй холбогдон гарах зардал, арбитраж шийдвэрээр гүйцэтгэсэн ажил нь үүрэгт хамаарахгүй бол ажлын хөлс, үзлэг хийхэд гарсан зардал, хэлмэрчлэл, орчуулга хийх, гэрчийн зардал, арбитраждын болон нарийн бичгийн даргын томилолтын зардал, арбитраж байнгын байрлах газраас өөр газарт арбитраж хуралдаан хийсэнтэй холбогдсон зардал болон бусад зардал орно.
- 4.2. Арбитраж аль нэг талаас эсвэл талуудаас хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой нэмэлт зардлыг урьдчилан төлүүлнэ. Нэмэлт зардалд төлсөн төлбөр илүү гарсан тохиолдолд арбитраж шийдвэр гарсны дараа тухайн илүү төлбөрийг буцаан олгоно.

Тав. Арбитраж ажиллагааны зардлаас буцаан олгох

- 5.1. Арбитраж ажиллагааны үндсэн зардлыг буруутай талаас нөхөн төлүүлнэ.

Зургаа. Арбитраж ажиллагаатай холбоотой бусад зардал

- 6.1. Аль нэг талын сонгосон арбитраж арбитраж ажиллагаа явуулах газарт байнга оршин суудаггүй тохиолдолд түүний арбитраж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохтой холбоотой гарах бүх зардлыг сонгосон тал төлнө. Хэрэв ийм арбитраж арбитраж бүрэлдэхүүний даргалагчаар томилогдсон бол түүнийг арбитраж ажиллагаанд оролцоход гарах зардлыг талууд тэнцүү хувааж төлнө.

Долоо. Арбитраж ажиллагааны зардлын талаарх талуудын эрх

- 7.1. Аль нэг тал арбитраж ажиллагаатай холбогдон өөрөөс гарсан нэмэлт зардлыг буруутай талаас нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх эрхтэй бөгөөд нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр энэхүү журамд заасны дагуу арбитраж зардлыг төлнө.
- 7.2. Аль нэг талын хүсэлтээр арбитраж хуралдаанд орчуулга хийх, баримт бичгийг орчуулах бол орчуулгын зардлыг хүсэлт гаргасан тал төлнө. Арбитраж бүрэлдэхүүний санаачлагаар баримт бичгийг орчуулах бол орчуулгын зардлыг талууд тэнцүү хувааж төлнө. Хэрэв талууд харилцан тохиролцон хуралдааныг Монгол хэлээс өөр хэлээр явуулахаар бол орчуулгын зардлыг талууд тэнцүү хувааж төлнө.
- 7.3. Аль нэг талын хүсэлтээр шинжээч томилох бол шинжээчийн зардлыг хүсэлт гаргасан тал, Арбитраж бүрэлдэхүүний санаачлагаар шинжээч томилох бол шинжээчийн зардлыг талууд тэнцүү хувааж төлнө.